

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл дараах байдлаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хэрэгжүүлнэ.”

Д/д	Хотын нэр	Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага	Хотын удирдлага
Улсын зэрэглэлтэй хот			
1	Багануур хот	Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Багануур хотын Зөвлөл
		Нийслэлийн Багануур дүүргийн Засаг дарга	Багануур хотын Захирагч
2	Налайх хот	Нийслэлийн Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Налайх хотын Зөвлөл
		Нийслэлийн Налайх дүүргийн Засаг дарга	Налайх хотын Захирагч

2 дугаар зүйл.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2, 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.